



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 2/2021

Чингис хот

Монголын эмэгтэйчүүдийн холбооны
Хэнтий аймаг дахь салбарт дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын эмэгтэйчүүдийн холбооны дүрэм шинэчлэгдсэнтэй холбогдуулан шинэ дүрмийг орон нутагт сурталчлах, бусад аймгуудын салбаруудтай харилцан туршлага солилцох, хамтран ажиллахад зориулан Монголын эмэгтэйчүүдийн холбооны Хэнтий аймаг дахь салбарт 3,000,000 /гурван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231012023